



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 213

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Захиргааны ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай” 799 дүгээр тогтоолын 1 дэх хэсгийг дараах өөрчилсүгэй.

1.1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 314 нэрийн, нийт 285,182,784.07 (хоёр зуун наян таван сая нэг зуун наян хоёр мянга долоон зуун наян дөрвөн төгрөг долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, 232,041,661.79 (хоёр зуун гучин хоёр сая дөчин нэгэн мянга зургаан зуун жаран нэгэн төгрөг далан есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасан дагуу балансаас балансад шилжүүлсүгэй гэж;

2.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 799 дүгээр тогтоолоор батлагдсан хавсралтын 10, 94, 161, 239, 253, 290, 309 дүгээр мөрүүдэд хавсралтад заасны дагуу өөрчлөлтийг оруулсугай.

3.“Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай” 799 дүгээр тогтоолоор батлагдсан хавсралтын 95 дугаар мөрийг хассугай.

4.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, хавсралтад заасан харьяа байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

4.1.Тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

4.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

4.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

5.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132000587
9-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 04 дугаар сарын 17-ны өдрийн
0413 дугаар тогтоолын хавсралт

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨНД БҮРТГЭЛТЭЙ,
ХАРЪЯА БАЙГУУЛЛАГУУДАД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
(төгрөг)								
1	Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар							
10	Сандал	2018-01-01	ширхэг	1	100,000	100,000.00	69,999.80	30,000.20
6	Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар							
94	Сандал	2023-03-28	ширхэг	2	86,275	172,550.00	123,121.81	49,428.19
11	Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар							
161	Сандал	2014-10-31	ширхэг	100	190,000	19,000,000.00	9,090,189.20	9,909,810.80
15	Хэнтий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар							
239	Сандал	2018-01-01	ширхэг	1	100,000	100,000.00	69,999.80	30,000.20
16	Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар							
253	Компьютер Дэлгэцтэй	2024-02-20	ширхэг	1	638,464	638,463.60	266,026.50	372,437.10
17	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори							
290	Хурлын ширээ	2014-10-31	ширхэг	1	240,000	240,000.00	111,666.67	128,333.33
19	Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар							
309	Компьютер Дэлгэцтэй	2024-02-20	ширхэг	1	638,464	638,463.60	266,026.50	372,437.10
	БҮГД ДҮН			651		285,182,784.07 (хоёр зуун наян таван сая нэг зуун наян хоёр мянга долоон зуун наян дөрвөн төгрөг долоон мөнгө)	232,041,661.79 (хоёр зуун гучин хоёр сая дөчин нэгэн мянга зургаан зуун жаран нэгэн төгрөг далан есөн мөнгө)	53,141,122.28 (тавин гурван сая нэг зуун дөчин нэгэн мянга нэг зуун хорин хоёр төгрөг хорин найман мөнгө)